



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/191/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА К.САГДАТ
ТАНАА

2026.02.16 № 71
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1.Эмийн тайлан бүртгэл тооцоо, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, эмийн бүртгэл тайлан тооцоо хангалтгүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй, бараа үйлчилгээний зардалд 223.7 сая төгрөгийн өр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.2, 16.5.4, 16.5.5, 16.5.6, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.2, 5.1.3, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтууд болон УСНББОУС 1 стандартад нийцэхгүй, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв нь 2025 онд 2,237.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 2,029.3 сая төгрөг зарцуулж, 91 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн төвийн бараа материалын бүртгэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	291,059,163.87	209,130,043.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,762,167.32	42,861,739.12
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,762,167.32	42,861,739.12
3121	Төгрөг	1,762,167.32	42,861,739.12
31211	Төрийн сангийн харилцах	1,751,910.32	41,045,035.86
31213	Арилжааны банк дахь харилцах	10,257.00	1,816,703.26
33	АВЛАГА	185,916,101.41	28,439,253.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,034,915.00	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	183,881,186.41	28,439,253.90
35	БАРАА МАТЕРИАЛ	103,380,895.14	137,829,050.14
351	Түүхий эд материал	32,254,320.00	62,906,975.00
35130	Эм боох материал	32,254,320.00	62,906,975.00
354	Хангамжийн материал	71,126,575.14	74,922,075.14
35420	Аж ахуйн материал	38,674,803.88	39,004,803.88
35460	Хүнсний материал	1,434,500.00	
35470	Бусад хангамжийн материал	31,017,271.26	35,917,271.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,592,327,134.69	1,750,360,536.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,592,327,134.69	1,750,360,536.17
392	Биет хөрөнгө	1,575,799,134.69	1,733,832,536.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,226,813,057.09	1,401,813,057.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(168,921,164.71)	(184,413,210.67)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	430,417,455.18	456,942,455.18
39204	Хуримтлагдсан элэгдэл	(150,360,309.52)	(177,578,610.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	311,608,226.34	324,712,226.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,520,930.35)	(157,060,231.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,917,000.00	102,917,016.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,179,199.34)	(33,525,165.92)
39217	Ном	25,000.00	25,000.00
393	Биет бус хөрөнгө	16,528,000.00	16,528,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,528,000.00	16,528,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,883,386,298.56	1,959,490,579.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96,889,209.68	223,719,847.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96,889,209.68	223,719,847.32
413	Өглөг	96,889,209.68	223,719,847.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	114,054,594.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	60,643,166.68	66,194,803.32
4136	Бусад өглөг	36,246,043.00	43,470,450.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,246,043.00	43,470,450.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,786,497,088.88	1,735,770,732.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,786,497,088.88	1,735,770,732.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	219,336,811.00	219,336,811.00
51101	Өмч: - төрийн	219,336,811.00	219,336,811.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,306,249,368.21	1,255,523,011.34
51210	Өмнөх үеийн үр дүн	976,321,130.03	1,306,249,368.21
51220	Тайлант үеийн үр дүн	329,928,238.18	(50,726,356.87)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	260,910,909.67	260,910,909.67

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,883,386,298.56</u>	<u>1,959,490,579.33</u>
---	--	--------------------------------	--------------------------------

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
Төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,128,872,249.85	2,131,442,744.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315,815,124.44	315,386,997.63
120	Нийтлэг татварын бус орлого	315,815,124.44	315,386,997.63
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	98,861,981.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	98,861,981.63
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	295,846,033.18	216,525,016.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	19,969,091.26	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,813,057,125.41	1,816,055,746.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,518,400.00	65,470,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,518,400.00	65,470,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,743,538,725.41	1,750,584,946.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,743,538,725.41	1,750,584,946.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,798,944,011.67	2,182,169,101.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,798,944,011.67	2,182,169,101.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,798,930,349.65	2,100,732,534.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,228,090,068.98	1,518,755,567.00
210101	Үндсэн цалин	698,465,448.52	882,352,773.14
210102	Нэмэгдэл	443,078,619.67	454,656,193.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,120,000.00	50,673,100.00
210104	Урамшуулал	76,426,000.79	131,073,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,689,500.00	161,205,036.00
210201	Тэтгэврийн даатгал	101,238,100.00	110,235,636.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,862,900.00	13,893,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,431,400.00	6,946,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,431,400.00	3,335,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,725,700.00	26,794,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,768,317.98	65,470,800.00
210301	Гэрэл, цахилгаан	7,733,729.98	9,315,915.00
210302	Түлш, халаалт	58,171,008.00	56,154,885.00
210303	Цэвэр, бохир ус	863,580.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	78,364,690.00	90,361,286.00
210401	Бичиг хэрэг	4,005,300.00	8,260,150.00
210402	Тээвэр, шатахуун	71,233,120.00	70,606,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528,000.00	1,818,709.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,298,270.00	9,676,337.00
2105	Нормативт зардал	136,275,638.60	174,867,961.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,419,376.60	144,735,131.11
210502	Хоол, хүнс	21,144,262.00	30,132,830.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	712,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,185,000.00	7,522,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,981,000.00
210604	Урсгал засвар	3,185,000.00	4,541,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,924,000.00	2,726,000.00

210702	Дотоод албан томилолт	2,924,000.00	2,726,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,750.00	55,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	281,800.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,217,384.09	79,768,884.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,279,622.00	8,173,270.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,937,762.09	71,595,614.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,662.02	81,436,566.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	81,436,566.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,870,566.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	61,566,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,662.02	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,662.02	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	329,928,238.18	(50,726,356.87)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	329,928,238.18	(50,726,356.87)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,629,175,939.00	2,070,359,660.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	98,861,981.63
120	Нийтлэг татварын бус орлого	-	98,861,981.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	98,861,981.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		98,861,981.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,629,175,939.00	1,971,497,679.31
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,518,400.00	65,470,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,518,400.00	65,470,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,559,657,539.00	1,906,026,879.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,559,657,539.00	1,906,026,879.31
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,616,865,172.21	2,016,156,089.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,616,865,172.21	2,016,156,089.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,616,851,510.19	1,934,719,522.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,224,486,890.29	1,393,398,094.00
210101	Үндсэн цалин	695,134,420.52	756,995,300.14
210102	Нэмэгдэл	442,806,468.98	454,656,193.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,120,000.00	50,673,100.00
210104	Урамшуулал	76,426,000.79	131,073,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,065,700.00	170,473,000.00
210201	Тэтгэврийн даатгал	106,614,300.00	114,898,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,862,900.00	13,893,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,431,400.00	6,946,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,431,400.00	6,946,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,725,700.00	27,787,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,904,737.98	65,470,800.00

210301	Гэрэл, цахилгаан	7,733,729.98	9,315,915.00
210302	Түлш, халаалт	58,171,008.00	56,154,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,725,230.00	83,708,356.00
210401	Бичиг хэрэг	4,005,300.00	6,025,500.00
210402	Тээвэр, шатахуун	69,964,660.00	72,802,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528,000.00	1,719,709.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,927,270.00	3,160,807.00
2105	Нормативт зардал	78,616,751.92	196,484,002.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,600,542.92	161,851,149.47
210502	Хоол, хүнс	6,304,209.00	30,956,353.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	712,000.00	3,676,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,985,000.00	14,132,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,591,000.00
210604	Урсгал засвар	4,985,000.00	4,541,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,924,000.00	2,726,000.00
210702	Дотоод албан томилолт	2,924,000.00	2,726,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	415,750.00	154,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	176,000.00	154,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	105,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,727,450.00	8,173,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,727,450.00	8,173,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,662.02	81,436,566.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	81,436,566.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		19,870,566.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		61,566,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,662.02	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,662.02	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,310,766.79</u>	<u>54,203,571.80</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,640,000.00	13,104,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,640,000.00	13,104,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,640,000.00	13,104,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,640,000.00	13,104,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,640,000.00)</u>	<u>(13,104,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	670,766.79	41,099,571.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,081,143.53	1,762,167.32
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,751,910.32	42,861,739.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	976,321,130.03	1,456,568,850.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	976,321,130.03	1,456,568,850.70
C07	Тайлант үеийн үр дүн			329,928,238.18	329,928,238.18
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	1,306,249,368.21	1,786,497,088.88
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	1,306,249,368.21	1,786,497,088.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	1,306,249,368.21	1,786,497,088.88
D08	Тайлант үеийн үр дүн			-50,726,356.87	-50,726,356.87
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,336,811.00	260,910,909.67	1,255,523,011.34	1,735,770,732.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,237,102,600.00	2,029,260,089.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,237,102,600.00	2,029,260,089.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,129,482,400.00	1,947,823,522.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,378,484,100.00	1,393,398,094.00
210101	Үндсэн цалин	869,495,700.00	756,995,300.14
210102	Нэмэгдэл	409,836,800.00	454,656,193.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,650,700.00	50,673,100.00
210104	Урамшуулал	53,500,900.00	131,073,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,874,900.00	170,473,000.00
210201	Тэтгэврийн даатгал	113,300,700.00	114,898,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,893,500.00	13,893,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,946,700.00	6,946,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,946,700.00	6,946,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,787,300.00	27,787,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,170,600.00	65,470,800.00
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	9,315,915.00
210302	Түлш, халаалт	58,170,600.00	56,154,885.00
2104	Хангамж, бараа материалын зардал	131,680,600.00	83,708,356.00
210401	Бичиг хэрэг	10,740,500.00	6,025,500.00
210402	Тээвэр, шатахуун	101,634,200.00	72,802,340.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,332,300.00	1,719,709.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,846,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,127,400.00	3,160,807.00
2105	Нормативт зардал	305,091,600.00	196,484,002.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	246,661,000.00	161,851,149.47
210502	Хоол, хүнс	45,822,300.00	30,956,353.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,608,300.00	3,676,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,535,000.00	21,236,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,501,000.00	16,695,000.00
210604	Урсгал засвар	21,034,000.00	4,541,000.00
2107	Томилолт, зочны зардал	11,024,600.00	2,726,000.00
210702	Дотоод албан томилолт	11,024,600.00	2,726,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,376,500.00	154,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	134,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	248,100.00	154,000.00
210807	Газрын төлбөр	120,800.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	873,600.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,244,500.00	14,173,270.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,244,500.00	14,173,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,620,200.00	81,436,566.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,620,200.00	81,436,566.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,878,200.00	19,870,566.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,742,000.00	61,566,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,237,102,600.00	2,068,542,957.68
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,670,600.00	65,470,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	82,670,600.00	65,470,800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,039,155,700.00	1,906,026,879.31
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,039,155,700.00	1,906,026,879.31
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	115,276,300.00	97,045,278.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,524,400.00	97,045,278.37
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,751,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,762,167.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		41,045,035.86
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	51	51
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41
620003	Үйлчлэх ажилтан	9	9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	51	51
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	42	42
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,798.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 26.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 32 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг байршуулаагүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн

арга хэмжээний тайланг байршуулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 ш худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг долоо хоногийн дотор мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.8 сая төгрөгийн 1 зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, өр төлбөр үүсгэсэн 227.3 сая төгрөгийн 14 шийдвэр болон төсөв, өмч хөрөнгө зарцуулах талаар гаргасан байгууллагын даргын шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 65.5 хувь байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.5-д "т..... аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны байршуулаагүй 227.3 сая төгрөгийн 29 мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөмж болгов.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 2018-2020 онд 86 нэр төрлийн 17,489.5 мянган төгрөгийн аж ахуйн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан боловч тухайн үед холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж баримтжуулаагүйтэй холбоотой одоог хүртэл үлдэгдлээр тайлагнаж ирсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.2-д "тасралтгүй байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Жилийн эцсийн хөрөнгө, бараа материалын тооллогыг иж бүрэн чанартай хийж, 2018-2020 онд зарцуулсан боловч үлдэгдлээр тайлагнаж ирсэн бараа материалын тооцоог дахин

хянаж холбогдох арга хэмжээг авч хууль журмын дагуу зарлагад гаргах, цаашид бараа материалын зарцуулалтыг тухай бүр баримтжуулж, тайлагнаж ажиллахыг зөвлөсөн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын дүнд хамруулж зөвлөмж өгөв.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 111.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 11.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчилд нэг албан тушаалтанд хариуцлага албан шаардлага, 66.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой 60.6 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	11,591.8	2	2000.0	17.2%
Албан шаардлага	1	38,771.4	1	38,771.4	100%
Зөвлөмж	2	60,643.2	2	60,643.2	100%
Нийт дүн	5	111,006.4	5	101,414.6	72.4%

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгахад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 0.2 сая төгрөгийн 1 төлбөрийн актын биелэлт, 60.6 сая төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлтийг хугацаандаа ирүүлсэн, 11.4 сая төгрөгийн төлбөрийн актаас 2.0 сая төгрөгийг барагдуулж үлдсэнийг хугацаа хэтрүүлж төлөөгүй тул Баян-Өлгий аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд төлбөр барагдуулах актыг баталгаажуулахаар шилжүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар илэрсэн зөрчилтэй асуудлуудыг дараагийн аудитаар эрсдэл тодорхойлох, горим сорил хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийтдээ 23.3 сая төгрөгийн алдаа² илэрч алдааг залруулав. Үүнд: *Залруулсан алдаа*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 17.2 сая төгрөгөөр дутуу, гүйцэтгэлийг 0.4 сая төгрөгөөр төгрөгөөр илүү, санхүүжих эх үүсвэрийг 0.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
- Тайлант оны эмийн өр төлбөрийг 3.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Тайлант онд эргэлтийн эмийн сангийн 1.8 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан байна.

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой 351.5 сая төгрөгийн зөрчил³ илэрч 122.4 сая төгрөгийн 2 зөвлөмж, 229.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

Аудитаар 229.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв. Үүнд:

1. Өмнөх онуудаас он дамжсан өр төлбөрт 44.9 сая төгрөг шилжүүлсэн боловч үүний 33.8 сая төгрөг нь бүртгэл тайланд тусгаагүй өр байсан ба эмийн тайлан, бүртгэл тооцоо хангалтгүй, өмнөх онуудын өр төлбөрийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, эмийн бүртгэл тайланд тавих дотоод хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2. Оны эцэст өр төлбөрийн үлдэгдэл 223.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 126.8 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнээс НДШ, ХХОАТ-т 114.0 сая төгрөгийн өртэй гарсан татаас санхүүжилтийн 28.4 сая төгрөгийн авлагыг хасаж тооцоход бодит өр төлбөр 195.3 сая төгрөг байна. Өмнөх оноос он дамжсан бараа үйлчилгээний зардлын өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, үр ашиггүй худалдан авалт хийсэн, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16. 5.7-д " Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тасралтгүй байх", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр", заалтууд ", 20 дугаар зүйлсийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч бүртэй нэг бүрчлэн тооцоо хийж, үлдэгдлийг үнэн зөв баталгаажуулах, эмийн тайлан, бүртгэл тооцоонд тавих дотоод хяналтыг дээшлүүлэх, бүртгэл тооцооны ажилтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах, төсвийг зохистой удирдаж өр төлбөр нэмж үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Аудитаар 122.3 сая төгрөгийн зөрчилтэй холбоотой 3 зөвлөмж өгөгдсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Завсрын аудитаар Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвд ажиллах үеэр хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд хийсэн түүвэрчилсэн тооллогын дүнгээр 2018-2020 онд зарцуулсан боловч бүртгэл тайланд тусгалгүй орхигдуулж үлдэгдлээр тайлагнаж ирсэн 17.5 сая

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн бараа материал байгааг илрүүлж, холбогдох арга хэмжээ авч зарлагад гаргах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.2-д "тасралтгүй байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаандаа 2018-2020 онд зарцуулсан 86 нэр төрлийн 17.5 сая төгрөгийн аж ахуйн материалыг зохих журмын дагуу шийдвэр гаргаж, зарлагад гаргах, бараа материалын бүртгэл тайлан, тооцоог сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байхыг зөвлөмж болгов.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төв нь 2025 онд батлагдсан төсвийн хүрээнд 68.1 сая төгрөгийн түлш, шатах тослох материал, 36.7 сая төгрөгийн хүнсний материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-д батлагдсан төсвийг 17.2 сая төгрөгөөр дутуу, гүйцэтгэлийг 0.4 сая төгрөгөөр, санхүүжих эх үүсвэрийг 0.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан.	1	17,998.1			1	17,998.1	1	17,998.0				
Тайлант оны эмийн өр төлбөрийг 3.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	3,582.9	1	3,582.9			1	3,582.9				
Эргэлтийн эмийн сангийн 1.8 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан.	1	1,816.7	1	1,816.7			1	1,816.7				
Дүн	3	23,397.7	2	5,399.6	1	17,998.1	3	23,397.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эмийн бүртгэл тайлан тооцоо хангалтгүй, өмнөх онуудын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй. Оны эцэст өр төлбөрийн үлдэгдэл 223.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 126.8 сая төгрөгөөр нэмэгдсэн ба татаас санхүүжилтийн 28.4 сая төгрөгийн авлагыг хасаж тооцоход бодит өр төлбөр 195.3 сая төгрөг байна	1	229,092.2			1	229,092.2						
2018-2020 онд зарцуулсан 17.5 сая төгрөгийн бараа материалыг	1	17,589.5					1	17,489.5				

зарлагад гаргаагүй үлдэгдлээр тайлагнасан.												
Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хэрэгжүүлээгүй.	1	104,812.7					1	104,812.7				
Дүн	3	351,494.4			1	229,092.2	2	224,376.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан	1	227,302.7			1	227,302.7		
Дүн	1	227,302.7			1	227,302.7		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	227,302.7			1	227,302.7		